



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 1423

Амардалай

Шүлхий өвчнөөс урьдчилсан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын 2022 оны 04 дүгээр сарын 08 -ний өдрийн А/77 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2022 оны А/174 дугаар захирамж, Аймгийн Онцгой комиссын 2022 оны 04 сарын өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сумын нийт малчин, мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэн, бэлэн байдлыг хангаж гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад үхэр сүргийг 100% хамруулах арга хэмжээг мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан "Шүлхийн дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах стандарт ажиллагааны заавар"-ыг баримтлан 2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулж ажиллахыг "Мал эмнэлгийн тасаг"-ийн дарга (Д.Наранцэцэг), малын эмч (М.Даваацэрэн), (Н.Балданжав), Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарь, дархлаажуулалтын зардлын хуваарь, дархлаажуулалтын явцад хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Гурав. Дархлаажуулалт, хяналтын шатахууны зардал 548,600 (таван зуун дөчин найман мянга зургаан зуу) төгрөг, туслах ажилтны томилолт 265,000 (хоёр зуун жаран таван мянга) бүгд 813,600 (найман зуун арван гурван мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын дарга (С.Нарантунгалаг), нягтлан бодогч (Б.Үүрийнтуяа) нарт зөвшөөрсугэй.

Дөрөв. Мэдрэмтгий мал, амьтныг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг дуустал 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хурдан морины уралдаан, отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнийг зогсоохыг Багийн Засаг дарга нар, Хэсгийн төлөөлөгч (Л.Отгонбаатар) нарт даалгасугай.

Тав. Дархлаажуулалтыг мэргэжил арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулж, тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Наранцэцэг) -т даалгасугай.



ДАРГА

М.БАЯРСҮХ

4880200515